

хөдөлгөөн гаргахад 1905 оны Оросын хувьсгал их нөлөө үзүүлсэн юм. Өвөр Монголд гарч байсан дугуйлангийн хөдөлгөөн болон манж хятадын ноёрхолыг эсэргүүцсэн ардын тэмцэл гарч байсныг тодорхой өгүүлэв. Доктор Ш. Сандаг «Богд хаант Монгол улс, түүний дотоод гадаад байдал» гэсэн илтгэл тавив. Илтгэгч, 1911 онд Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээн мандуулах тухай тунхаг бичиг гаргаж, Богд хаант Монгол улс байгуулсан явдал бол монголын түүхэн дэх чухал үйл явдал мөн гэж цохон тэмдэглэв. Дэд эрдэмтэн Р. М. Неронов, ДДСХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд эрдэмтэн Ч. Далай нар 1911 оны монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухай дэлгэрэнгүй ярьж, монголын ард түмний

үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө явуулсан тэмцлийн мөн чанарыг маогийнхан үгүйсгэж, түүний түүхийг санаатайгаар гуйвуулж байгааг илчлэн шүүмжилж хөдөлшгүй баримтаар няцаахын хамтаар уг эрдэм шинжилгээний бага хурал цаг үеэ олсон чухал ач холбогдолтой болсныг илтгэлдээ тэмдэглэв.

Түүнчилэн түүхийн ухааны дэд эрдэмтэн А. Дамдинсүрэн «Өвөр Монголд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн», Н. Ариунгуа «Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтийн эсрэг Юань Шикайн засгийн явуулсан бодлого» гэсэн сэдвээр дэлгэрэнгүй үг хэлэв.

Ж. Баясах

БНМАУ: КАПИТАЛИЗМЫГ АЛГАСАН СОЦИАЛИЗМЫН ЗАМ (Москвад болсон «дугуй ширээний» ярилцлага)

Монгол ардын хувьсгалын 60 жилийн ойн өмнө Хэвлэлийн Новости Агентлаг, МОНЦАМЭ агентлагтай хамтран «Капитализмыг алгасан социализмын замаар замнаж яваа БНМАУ-ын хөгжлийн туршлагын олон улсын ач холбогдол» сэдвээр Москвад «дугуй ширээний» ярилцлага зохион явуулав. Ярилцалгад МАХН-ын Төв Хорооны дэргэдэх намын түүхийн институт (одоо Нийгмийн ухааны институт)-ийн орлогч захирал, түүхийн ухааны доктор А. Минис, дэд эрдэмтэн Б. Лигдэн, сэтгүүлч Х. Чулуунгомбо, Хэвлэлийн Новости Агентлагийн захиргааны орлогч дарга, ЗСБНХУ-ын төрийн шагналт И. Н. Медведев, түүхийн ухааны доктор, профессор М. С. Капица, дэлхийн социалист системийн эдийн засгийн институтийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, түүхийн ухааны дэд эрдэмтэн Т.А. Якимова, «Правда» сонины социалист орнуудын редакцийн орлогч эрхлэгч, түүхийн ухааны дэд эрдэмтэн В. Шаров, ЗСБНХУ-ын Шинжлэх ухааны Академийн Дорно дахины судлалын институтийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн К. Яцковская нарын зэрэг хүмүүс оролцов.

Зөвлөлт, монголын нэрт эрдэмтэд, сэтгүүлчид, нийгмийн зүтгэлтнүүд гүн гүнзгий агуулгатай мэдээлэл хийв. Хэвлэлийн Новости агентлагийн захиргааны орлогч дарга И. Н. Медведев «Дугуй ширээний» ярилцлагад хэлсэн үгэндээ:

—Колонийн систем балран унасны дүнд

үндэсний тусгаар тогтнолоо олж, нийгэм-эдийн засгийн эрс өөрчлөлтийн замд орсон улс түмнүүдэд урьд хоцрогдсон орнууд капиталист хөгжлийн шатыг алгасан социализмд шилжсэн олон улсын туршлагыг судлан ашиглах явдал чухал ач холбогдолтой юм. Энэ талаар монголын ард түмэн нэн баялаг туршлагатай билээ гэж тэмдэглэжээ. Тэр цааш нь хэлэхдээ: «Аугаа их Октябрийн социалист хувьсгалаар эхэлсэн дэлхийн хувьсгалт үйл явцад Азийн хамгийн хоцрогдсон орнуудын нэг байсан Монгол орон ХХ зуунд феодализмаас социализмд шилжиж, олон зуун жилийн хоцрогдол, үгүйрэл хоосролоос дэвшил хөгжлийн түүхэн үсрэлт хийв...

Марксизм-ленинизмийн мөнхийн амьд сургаал, пролетарийн интернационализмын зарчмыг хэлбэрэлтгүй удирдлага болгож, шинэ амьдрал байгуулахад монголын хөдөлмөрчдийн шалгарсан манлайлагчийн үүргийг нэр төртэй биелүүлж байгаа МАХН, монголын ард түмний олсон амжилт үнэлж баршгүй гавъяа байгуулсан юм» гэж цохон тэмдэглэв.

Социалист байгуулалт дахь БНМАУ-ын туршлагын талаар ярихдаа: Ази, Африк, Латин Америк, Океанийн зуу гаруй орон хоцрогдлыг устгах эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх замын тухай асуудлыг шийдвэрлэж байгаа одоо үед тэдний ихэнх нь ЗСБНХУ-ын үндэсний бүгд найрамдах улсууд, түүнчилэн түүхэн богино хуга-

цаанд түүхийн бүхэл бүтэн үе-капитализмыг алгасан феодализмаас социализмд дэвшин орсон БНМАУ-ын туршлага руу анхаарлаа хандуулж байна, зайлшгүй хандуулах ч болно.

«Хоцрогдсон орнууд тэргүүний орны пролетарийн тусламжтайгаар зөвлөлт байгуулал ба хөгжлийн тодорхой шатыг дамжиж, капитализмыг алгасан коммунизмд хүрч болно» гэж В. И. Лениний заасан ёсоор Монгол орон хөгжсөн нь тийм туршилтыг хэрэгжүүлэх боломжтой болгосон юм гээд колонийн талхигдлаас чөлөөлөгдсөн улс түмэнд нийгмийн дэвшлийг гагцхүү социалист зам авч ирнэ гэдгийг капитализмын өмнөх нийгмээс социализмд орсон БНМАУ, бусад орны түүхэн туршлага бат нотлон харуулж байна гэж тэмдэглэжээ.

Зөвлөлт-монголын найрамдал бол ах дүү ёсоор харилцан туслалцахын үлгэр дууриал мөн гэж түүхийн ухааны доктор А. Минис тэмдэглээд улс хоорондын шинэ маягийн харилцааны үлгэр дууриал болсон манай хоёр ард түмний найрамдал, хамтын ажиллагаа өнөө үед хөгжлийнхөө чанарын шинэ шатанд орсон ба түүний онцлог нь:

Нэгдүгээрт, энэ харилцаа марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын эв санааны нэгдлийн бат бэх зарчим, төрийн тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх жинхэнэ тэгш эрх, нөхөр ёсны дэмжлэг, нягт хамтын ажиллагаа, социалист ёсоор харилцан туслалцахад тулгуурлаж байгаа.

Хоёрдугаарт, монгол-зөвлөлтийн харилцаа нь хөрш хоёр орны зүгээр нэг харилцаа биш харин хувьсгалт хоёр хүчний ангийн холбоо,

Гуравдугаар, Монгол-зөвлөлтийн найрамдлыг манай ард түмэн өнөө хүртлэх хугацаанд олсон үлэмж их хувьсгалт ололтын нэг гэж зүй ёсоор үзэж буй,

Дөрөвдүгээрт, Монгол-зөвлөлтийн найрамдал үнэхээр бүх талыг хамарч байна. Одоо БНМАУ ЗХУ-тай ойртох процесс нийгмийн амьдралын бүх салбарт эрчимтэй хөгжиж байна гэв.

БНМАУ дахь социалист байгуулалтын туршлага, практик, онолын ач холбогдлын талаар дэд эрдэмтэн Т. А. Якимова, Социалист нөхөрлөлийн орнуудын үзэл суртал-улс төрийн нэгдлийг бэхжүүлэхэд МАХН-ын оруулсан хувь нэмрийн талаар дэд эрдэмтэн Б. Лигдэн, БНМАУ олон улсын энх тайван, ардчилал, социализмын төлөө тэмцэлд сэдвээр Х. Чулуунгомбо нар тодорхой яриу.

Б. Лигдэн хэлсэн үгэндээ «Маоизм империализмын хамгийн харгис бүлэгтэй нэгдэн нийлж, социализмыг дайсагнасан хүч болж байна. Бээжингийн удирдлагын улс төрийн хорлон сүйтгэх объектуудын нэг нь Монгол юм. Орчин үеийн нөхцөлд их хан үндэстний харгис бодлогыг үргэлжлүүлж байгаа бээжингийн удирдагчид айл хөрш орнуудыгаа, түүний дотор Монголыг түрэмгийлэн эзлэх зорилго тавьж, тэгснээрээ монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд шууд заналхийлж байна. Ийм нөхцөлд маоизмын үзэл санааны мөн чанарыг илчлэхийн хамт БНМАУ-ын батлан хамгаалах чадварыг хангах нэмэгдэл арга хэмжээ авч байна» гэж тэмдэглэжээ.

Эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтийг соёлын хувьсгалгүйгээр хийх боломжгүй гэсэн Лениний сургаалын үнэн мөнийг монголын ард түмэн амьдралд нотлон харуулсан тухай дэд эрдэмтэн К. Яцковская. Зөвлөлт-монголын ах дүүгийн найрамдалт хамтын ажиллагааны цар хүрээ, үр шимийн талаар дэд эрдэмтэн В. Шаров нар дэлгэрэнгүй яриу.

Х. Чулуунгомбо